

## СУРГАЛТ СУДАЛГААНЫ АЖЛЫН ЯВЦЫН ТҮВШИН

Ахисан түвшний сургалтанд хамрагдаж байгаа докторантын суралцах идэвхи чармайлт, удирдагч болон зөвлөхтэй хамтарч ажилласан байдал буюу сурах, сургах үйл ажиллагааг бодитой үнэлэх, докторын эрдэм шинжилгээ, судалгааны ажил нь тухайн суралцаж буй түвшний үе шатанд хийгдсэн буюу зохих хэмжээнд хүрсэн эсэхийг тогтоож, үнэлэлт дүгнэлт өгөх зорилготойгоор ШУТИС-ийн Ректорын 2007 оны 258 тоот тушаалаар баталсан “ШУТИС-д магистр, докторын сургалт явуулахад баримтлах журам”-ын 12 зүйлийг үндэслэн 2007 оны 10-р сарын 29-нөөс 11-р сарын 20-ныг хүртэл 21 хоногийн хугацаатай ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, төвүүдэд “Докторантын сургалт, судалгааны явцын түвшинг тогтоох ажил”-ыг зохион байгуулан явууллаа.

Сургалт, эрдэм шинжилгээний ажлын түвшин тогтоох комиссыг докторын сургалт явуулдаг бүрэлдэхүүн сургууль, төвүүдийн мэргэжлийн салбар бүрт байгуулан ажилласан бөгөөд бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд 3 хүнтэй зөвлөлийг эрдэмтэн нарийн бичгийн даргаар ахлуулж, профессорын багуудын төлөөлөл болох эрдэмтдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажилсан.

Профессорын багаас өөрийн багт харъяалагдах докторант нэг бүрийн сургалт судалгааны үр дүнг гаргаж бүрэлдэхүүн сургуулийн салбар комиссод танилцуулсан ба уг үйл ажиллагаанд докторант нар өөрийн биеэр оролцсон болно.

Докторант нь сургалт, судалгааны ажлын түвшинг тогтоолгохдоо дараахь материалуудыг бүрдүүлж үнэлгээ авсан байна. Үүнд:

- а. Докторант нь сургалтын хөтөлбөрийн дагуу зохих хичээлийг судалж дүгнэгдсэн үнэлгээний хуудас;
- б. Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинарт илтгэл тавьж хэлэлцүүлсэн болон эрдэм шинжилгээний сэтгүүл, эмхэтгэлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн тухай удирдагчийн дүгнэлт;
- в. Сэдвийн дагуу явуулсан туршилт, судалгааны ажлын явц, үр дүнгийн тухай докторантын тайлан;
- г. Докторантын хувийн ажлын төлөвлөгөөний дэвтэр дэхь судалгааны ажлын явц, тухайн хичээлийн жилд хийж гүйцэтгэсэн ажлын биелэлтийн талаархи удирдагчийн тодорхойлолт, төлөвлөгөө зэргийг хавсаргасан байна.

Профессорын багуудаас докторантын сургалт судалгааны явцын түвшинд өгсөн үнэлгээнд бүрэлдэхүүн сургуулийн салбар комисс хяналтын магадалгаа хийсний үндсэн дээр докторантыг цаашид үргэлжлүүлэн сургах, хасах, шилжүүлэх, жилийн чөлөө олгох эсэх талаархи протоколыг нэгтгэн хэлэлцэж гаргасан саналыг сургуулийн захирлын зөвлөлд танилцуулж, шийдвэрийг ШУТИС-ийн МДА-нд ирүүлсэн бөгөөд ирүүлсэн мэдээ баримтыг нэгтгэн дүгнэвэл ШУТИС-ийн хэмжээнд **2007-2008** оны хичээлийн жилийн байдлаар МДА-нд бүртгэлтэй байгаа нийт **743** докторантаас шинээр элссэн докторант **92**, эрдмийн зэрэг хамгаалсан **26**, докторын сургалтын хөтөлбөрийн кредит цагийг бүрэн биелүүлж гэрчилгээ авах **38** докторант байгаа ба аттестатчилалд хамрагдвал зохих нийт **566** докторантаас **406** нь аттестатчилалд хамрагдсан дүнтэй байна. Аттестатчиллын дүнгээс харахад, гадаадад суралцаж байгаа **5** докторант, сургалтаас 1 жилийн чөлөө авахаар **28**, докторантын сургалтаас чөлөөлж хасахаар **29** докторант, **8** докторант өөр сургуулийн докторантурт шилжүүлэхээр, тодорхой бус шалтгаанаар аттестатчилалд хамрагдаагүй **59** докторантыг дахин аттестатчилах тухай асуудлыг Ректорын зөвлөлд оруулахаар шийдвэрлээд байна.

## 2007-2008 оны хичээлийн жилийн докторантурт суралцагсдын

## сургалт, судалгааны явцын түвшинг тогтоох нэгдсэн дүн

Д/д	Харьяалах сургууль	Нийт докторантын тоо	ҮҮНЭЭС							2007-2008 оны хичээлийн жилд			2007-2008 онд үргэлжлүүлэн сурах	
			шинээр элссэн	гэрчилгээ авсан	гэрчилгээ авах	хамгаалсан	хасагдах	шилжсэн	чөлөө авсан болон авах	гадаадад суралцаж байгаа	Сургалт, судалгааны явцын түвшинг тогтоолгох	Сургалт, судалгааны явцын түвшинг тогтоолгосон		Сургалт, судалгааны явцын түвшинг дахин тогтоолгох
1	БИС	75	5		3						75	30		
2	ГГТС	52	5		5				7	4	52	40	12	12
3	ХБС	35	7		1		4	2	3		35	35		24
4	КТМС	61	9	7	6		7	1			61	36	8	
5	Мат.С	12	1		3						12	8	4	
6	МТС	34	1	12	2						25	25	1	9
7	МИС	59	10	15	3		4				59			18
8	УУИС	68	4	15	6		4	2	2		65	52	12	
9	ҮТДС	55	6	22	1		1	1	5	1	55	49	2	18
10	ХМТС	45	3	16	4			5			45	22	18	15
11	ХУС	24	4	3			5		2		22			6
12	ХБТС	81	16		1	5	2	1			44	39	5	47
13	ЭХИС	83	9	31	7	2					83	79	4	27
14	Дар.ТС	9	1	3	1				1		9	8	1	3
15	ОУДБСТ	40	6	7					7		33	26	7	24
16	ССТ	11	2	2			2	1	1		11	9	3	4
ДҮН		744	89		43	7	29	13	28	5	686	458	77	207

Докторантуудын хувийн хариуцлага, ажил, амьдралын зохицуулалт муугаас хамгаалалт хойшлох, сургалтаа орхих, чөлөө авах байдал нийтлэг болоод байна. ШУТИС-ийн хэмжээнд докторантурт 1992 онд элсэн орсон 1, 1995 онд элсэн орсон 1, 1997 онд элсэн орсон 2, 1998 онд элсэн орсон 3, 1999 онд элсэн орсон 14, 2000 онд элсэн орсон 40, 2001 онд элсэн орсон 41, 2002 онд элсэн орсон 42, 2003 онд элсэн орсон 74, 2004 онд элсэн орсон 82 докторант байгаа нь докторант нарын сургалт, судалгааны ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.